



# **МАНДАХ ИХ СУРГУУЛЬ**

**ОЮУТНЫ ОВОГ НЭР**

## **СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДВИЙН НЭР**

Мэргэжлийн индекс: Dxxxxxx

.....-ийн бакалаврын зэрэг горилсон бүтээл

**УЛААНБААТАР ХОТ**  
**2023 ОН**



## **МАНДАХ ИХ СУРГУУЛЬ**

**ОЮУТНЫ ОВОГ НЭР**

### **СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДВИЙН НЭР**

Мэргэжлийн индекс: Dxxxxxx

.....-ийн бакалаврын зэрэг горилсон бүтээл

Удирдагч: ..... Док(PhD), проф. Б. Мөнхсарнай

Шүүмжлэгч: ..... Док(PhD), дэд проф. Г. Мөнхзаяа

**УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН**

## **ТАЛАРХАЛ**

Энэ хэсэгт талархал оруулна уу.

## СУДЛААЧИЙН ЁС ЗҮЙН БАТАЛГАА

“.....” сэдэвт бакалаврын дипломын ажил нь миний өөрийн бүтээл бөгөөд нийт . . . . хуудастай, Монгол Улсын оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь Мандах их сургуулийн өмч болох бөгөөд тус сургуулийн номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Гарын үсэг: .....

Оюутны нэр: .....

Оюутны код: .....

Огноо: 2023.01.01

## **ХУРААНГУЙ**

Хураангуй нь таны судалгааны ажлыг бүхэлд нь товч байдлаар илэрхийлсэн бичвэрийн чухал хэсэг бөгөөд дипломын ажлыг бүрэн хийж дуусгасны дараа бичнэ. Хураангуй хэсэгт судалгааны зорилго, судалгааны үндэслэл, арга зүй (түүвэр, хугацаа, шинжилгээний арга зүй), судалгааны үр дүн, ерөнхий дүгнэлтийг тус бүр нэгээс хоёр өгүүлбэрээр товч тодорхой бичнэ. Бакалаврын дипломын ажлын хураангуй нь 150-200 үгтэй байна.

**Түлхүүр үг:** Судалгааны үндсэн чиглэлийг илэрхийлэх 3-5 түлхүүр үг байна, холбоо үгийг нэг үгэнд тооцно.

## АГУУЛГА

<b>ХУРААНГУЙ</b> .....	<b>III</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>V</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>VI</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>VII</b>
<b>ОРШИЛ</b> .....	<b>1</b>
<b>1 НЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ, ОНОЛ АРГА ЗҮЙ</b> .....	<b>1</b>
1.1 ДЭД БҮЛГИЙН ГАРЧИГ .....	1
<b>ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	<b>2</b>
2.1 ДЭД БҮЛГИЙН ГАРЧИГ .....	3
<b>ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН</b> .....	<b>3</b>
<b>ДҮГНЭЛТ</b> .....	<b>5</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b> .....	<b>6</b>
<b>ХАВСРАЛТ 1 НЭРИЙГ БИЧНЭ ҮҮ</b> .....	<b>I</b>
<b>ХАВСРАЛТ 2 НЭРИЙГ БИЧНЭ ҮҮ</b> .....	<b>II</b>

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Бичвэрт ашигласан график, зураг, диаграммын жагсаалтыг энэ хэсэгт харуулна.

Зураг 2. 1 Зургийн нэр.....3

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Бичвэрт ашигласан хүснэгтийн жагсаалтыг энэ хэсэгт харуулна.

Хүснэгт 1.1 Хүснэгтийн гарчиг.....1



## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

Бичвэрт ашиглагдсан товчилсон үгийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар монгол, англи, бусад хэл гэсэн дарааллаар байрлуулна.

<b>БОНЗ</b>	Байгаль орчин, нийгэм, засаглал
<b>БОНУ</b>	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
<b>НЯМТ</b>	Нүүрс төрөгч ялгаруулалтыг нийтэд ил тод мэдээлэх төсөл

## ОРШИЛ

Оршил хэсэгт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Судалгааны ажлын сэдвийн үндэслэл
- Судалгааны ажлын зорилго, зорилтууд
- Судалгааны ажлын шинэлэг тал, практик ач холбогдол
- Судалгааны түүвэр, судалгааны өгөгдөл, судалгааны хамрах хугацаа, судалгаанд ашигласан гол арга зүй /товч бичнэ/
- Судалгааны үр дүн болон дүгнэлт /товч бичнэ/
- Судалгааны ажлын бүтэц

## НЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ, ОНОЛ АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын сэдвийн хүрээнд өмнө нь хийгдсэн дотоод, гадаадын судалгааны өнөөгийн байдлыг бичнэ. Ингэхдээ судлаач өмнө нь хийгдсэн судалгааны ажлуудын дэвшүүлсэн асуудал, үндэслэл, арга зүй, үр дүнд өөрийн дүгнэлтийг хийж, утга агуулгаар төрөлжүүлэн логик дараалалд оруулж, бүлэглэн бичнэ. Нэгдүгээр бүлэгт сэдвийн судлагдсан байдал, судалгааны онол арга зүйн аль нэгийг сонгон бүлгийн нэрийг өгнө.

### Судалгааны таамаглал

Судалгааны онол, өмнө нь хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн таамаглал дэвшүүлж нэгдүгээр бүлэгт бичнэ. Судалгааны ажил нь хэд хэдэн таамаглал дэвшүүлж болох ба таамаглал бүрийн дээр дэвшүүлж буй үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлана. Судалгааны таамаглал нь дараах шалгуурыг хангасан байна.

- Судалгааны ажлын зорилгод нийцсэн байх
- Тодорхой судалгааны арга зүйгээр шалгагдах боломжтой;
- Логик уялдаатай
- Үг үсгийн сонголт оновчтой, алдаагүй байх

**Н1:** Судалгааны таамаглалыг энд бичнэ.

Судлагдсан байдлын тоймыг бичих нь сэдвийн талаар системтэй ойлголттой болж, өмнө нь судлагдсан хэсгийг тодорхойлж өөрөө түүнд ямар хувь нэмэр оруулснаа тодорхойлох боломжийг олгодог.

### 1.1 Дэд бүлгийн гарчиг

Хүснэгт 0.1 Хүснэгтийн гарчиг

Эдийн засгийн салбар	Компани	
	Монгол	Солонгос
1 Худалдаа үйлчилгээ	29	15
2 Уул уурхай олборлох үйлдвэр	22	-
3 Харилцаа холбоо, мэдээллийн технологи	8	22
4 Хүнсний үйлдвэрлэл	9	5

5	Газрын тос хангамж	8	-
6	Банк санхүү	6	12
7	Хүнд үйлдвэр	6	16
8	Барилга зам	5	-
9	Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж	3	7
10	Тээвэр логистик, бусад	3	-
11	Хөнгөн үйлдвэр	1	10
12	Эмнэлгийн үйлчилгээ	-	13
<b>Нийт</b>		<b>100</b>	<b>100</b>


*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2018)*

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт судалгааны зорилгодоо хүрэхийн тулд өгөгдөлд ямар арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийснээ тайлбарлана. Судалгааг хэрхэн хийсэн, мэдээллийн эх үүсвэрээ хэрхэн бүрдүүлсэн, судалгааны арга зүйг ашигласан зэрэг асуултад хариулна. Шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгааны арга зүйгээр ашигласнаар судалгааны ажлын үр дүн, бусдад итгэл үнэмшил төрүүлнэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ бүлэгт дараах зүйлсийг тусгана.

- 2.1. Судалгааны өгөгдөл - Түүвэр болон эх олонлог, өгөгдөл цуглуулах арга зүй, судалгааны хамаарах хугацаа гэх мэтийг бичнэ.
- 2.2. Судалгааны хувьсагч - Хувьсагчдын тодорхойлолт болон хэмжих, тооцоолох арга зүйг дэлгэрэнгүй бичнэ.
- 2.3. Судалгааны арга зүй - Тухайн судалгааны арга зүйн онолын үндэслэл, өмнө нь хийгдэж байсан судалгааны арга зүйг дурдаж, өөрийн судалгааны загвар (туршилт судалгааны арга зүй, кейс судалгаа гэх мэт) -ыг тайлбарлана.
- 2.4. Судалгаа шинжилгээний хэсэг - Дэвшүүлсэн таамаглалаа шалгахад ашигласан математик тооцоолол, статистик болон эконометрикийн арга хэрэгслүүдийн талаар бичнэ. Судалгааны ажилд судалгаа шинжилгээний хэд хэдэн аргыг ашиглаж болох бөгөөд яагаад ашиглах болсон талаар энэ бүлэгт тайлбарласан байна.
- 2.5. Судалгааны ажлын хязгаарлагдмал тал – Энэхүү судалгааны ажилтай холбоотой хязгаарлагдах бүх нөхцөлүүдийг дэлгэрэнгүй байдлаар дугаарлаж бичнэ. Дүгнэлт хэсэгт товч байдлаар оруулна.

## 2.1 Дэд бүлгийн гарчиг



Зураг 2. 1 Зургийн нэр

Эх сурвалж: (Chandok & Singh, 2017)

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ хэсэгт судалгааны ажлын үр дүнг дэлгэрэнгүй байдлаар тайлбарлан бичнэ.

1) Судалгааны тойм статистик: Судалгааны тойм хэсэгт судалгааны асуулт болон таамаглалын хүрээн дэх үр дүнг зохистой хэлбэр (бүдүүвч, хүснэгт, зураг, диаграмм)-ийг ашиглан тайлбарлана.

2) Судалгааны үр дүн гэсэн хэсэгтэй байна. Судалгааны үр дүн хэсэгт хийгдсэн статистик болон эконометрик шинжилгээний үр дүнг бичихдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Судалгааны зорилго, асуулт, дэвшүүлсэн таамаглалтай хэрхэн холбогдож буйг судлагдсан байдал, онолын тойм судалгаа болон онол арга зүй ашиглан тайлбарлах
- Өмнөх бүлэгт сонгосон арга зүйд тулгуурлан хийсэн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын үр дүнг нэгтгэж, боловсруулалт хийсэн байх ба шинжилгээ бүрийн арга зүйг тодорхой үндэслэлтэйгээр тайлбарлана.
- Судалгааны дэвшүүлсэн таамаглал дэмжигдсэн болон няцаагдсан эсэхийг таамаглал тус бүрээр үндэслэлтэй, логик дэс дараалалтайгаар тайлбарлана.
- Үр дүнгүүдийг танилцуулахдаа өөрийн цуглуулсан анхдагч мэдээллүүдийг хүснэгт, зурган хэлбэрээр бичиж, тайлбарлах
- Хүснэгт болон зургийг хуудас дамнуулах, дараагийн хуудсанд үргэлжлүүлэхгүй байх, нэг хуудсанд багтаах нь зохимжтой.
- Хэт олон зураг, хүснэгтийг нэг дор олноор нь оруулахгүй байх

- Хүснэгт, зураг тус бүрийн доор тайлбар бичсэн байх
- Сэдвийн агуулга, зорилготой хамааралгүй субъектив тайлбар хийхгүй байх

## ДҮГНЭЛТ

- Судлаач зорьсон зорилгодоо хүрсэн эсэхийг дурдаж, судалгааны ажлын хүрээнд хийсэн эмпирик судалгааны ажлын гол үр дүнг нэгтгэн бичнэ.
- Дүгнэлтийг хүүрнэх өгүүлбэрийн хэлбэртэйгээр дугаарлан бичих нь зохимжтой.
- Судалгааны ажлын таамаглал дэмжигдсэн, няцаагдсан эсэх дээр дүгнэлт бичнэ.
- Судалгааны ажлын оршил хэсэгт дурдсан судалгааны зорилго, зорилтуудтай гаргасан дүгнэлт нь агуулгын хувьд нийцэж байна.
- Судалгааны үр дүнд цаашид анхаарал татсан асуудлыг тусгайлан жагсаан бичнэ. /хэлэлцүүлэг/
- Судалгааны хязгаарлах нөхцөлүүдийг дурдаж бичнэ. (хязгаарлах нөхцөлүүдийг тусад нь дугаарлан бичиж болно)
- Судалгаагаар хийгдсэн ажлуудаа дурдаад, цаашид энэхүү сэдвийн хүрээнд хийгдэх боломжит судалгааны хоосон орон зай (research gap)-ыг жагсаан бичнэ.
- Судалгаа хийхэд гарсан хүндрэл бэрхшээлийг дурдаж, биелэгдээгүй таамаглал болон зорилгод хүрээгүйн шалтгааныг тайлбарлан бичнэ.
- Судалгааны үр дүнд үндэслэн санал болгож буй зөвлөмж, төсөл зэргийг хавсралтаар оруулна.
- Дээр дурдагдаагүйгээс бусад зайлшгүй дүгнэлт хэсэгт бичих зүйл байвал бичнэ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Судалгааны ажлын төгсгөлд эшлэл татсан ном, зохиолын нэрсийг тавих ба өгүүлэлд эш татсан дарааллаар нь дугаарлана. Нэрсийг Times New Roman фонд дээр 12pt үсгийн өндөртэйгөөр дараах хэлбэрээр бичнэ. Ашигласан материалын жагсаалтыг APA (The Association outlines the style in the Publication manual of the American Psychological Association) стандартын дагуу бичнэ. Иш татаагүй эх үүсвэрийг ашигласан материалын жагсаалтад тусгахгүй. Хэрэв албан ёсны вэбсайт ашигласан бол APA стандартыг ашиглан оруулна. Ашигласан материалын жагсаалтыг монгол хэл дээр болон гадаад хэл дээр бичигдсэнээр ангилан цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ.

1. Ванчигсүрэн, Д. (1996). Шавь төвтэй сургалтын онол, аргазүй. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар хот: Монгол.
2. Jamyansuren, S. (2015). Business methodology. Ulaanbaatar: Press Lord LLC.
3. Бэгз, Н., Нямдаваа, Ё. (1995). Монголын боловсролын түүхийн унших бичиг. Улаанбаатар хот: Монгол. 77х
4. Мандах Их Сургууль, (2017). Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандарт: 1.9 Судалгааны ажил, Улаанбаатар хот. Монгол. 9х

## **ХАВСРАЛТ 1 НЭРИЙГ БИЧНЭ ҮҮ**

Судалгааны ажлын үндсэн хэсэгт оруулах шаардлагагүй нэмэлт материалыг Хавсралт 1, Хавсралт 2 гэх мэтчилэн дугаарлан бичнэ. Гэхдээ үндсэн бичвэрт заавал хавсаргасан талаар тайлбар бичнэ.



**ХАВСРАЛТ 2 НЭРИЙГ БИЧНЭ ҮҮ**

**ABSTRACT** (in English)

The [abstract](#) is a short summary of your entire dissertation. It concisely reports the aims and outcomes of your research, and is generally around 150-200 words long, or no more than one page. Write the abstract last, when you've completed the rest of the dissertation.

State your [research problem](#) and [objectives](#):

- Briefly describe the problem or question your dissertation addresses.
- State your specific objectives.
- Use the present or simple past [tense](#).

Describe your [methods](#):

- Describe how data was gathered and analyzed.
- Use the simple past tense.

Summarize your key [results](#) or [arguments](#):

- Highlight the most important findings here.
- Use the simple past tense.

Present your [conclusion](#):

- State the answer to your main research question.
- Mention any important limitations or recommendations.
- Use the present tense.

**Keywords:** (in English)

**Судалгааны ажилд өргөн хэрэглэгддэг үгсийн жагсаалт**

1. Хураангуй – Abstract
2. Түлхүүр үг - Keyword
3. Оршил – Introduction
4. Судлагдсан байдал – Literature review
5. Онолын үндэслэл – Theoretical framework
6. Судалгааны арга зүй – Research method
7. Тойм статистик – Descriptive statistic
8. Судалгааны үр дүн – Research results
9. Хэлэлцүүлэг – Discussion
10. Дүгнэлт - Conclusion
11. Ашигласан материал – References
12. Хавсралт – Appendix
13. Таамаглал – Hypothesis
14. Хязгаарлалт - Limitation